

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 8
1.	<i>Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал</i>	5 – 6
2.	<i>Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал</i>	6 – 8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 15 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, С.Зулпхар, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин, Б.Хэрлэн, Д.Энхтуяа, М.Энхцэцэг.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалааг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Энхнасан: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Бадрахын Найдалааг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 1
Бүгд: 19
94.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Энхнасан: Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Л.Энхнасан: Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүнийг бүрэлдэхүүнийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 30 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 11 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
11 цаг 15 минут

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Гишүүдийн өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56.7 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д гишүүдийг сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, 10 дугаар тойрог Цэндийн Баатархүү гишүүн, 10 дугаар тойрог Отгоншарын Батнайрамдал гишүүн, 10 дугаар тойрог Хөхүүгийн Болормаа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн, 12 дугаар тойрог Тогтмолын Мөнхсайхан гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Бадрахын Найдалаа гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Болдын Уянга гишүүн, 1 дүгээр тойрог Ганбатын Хосбаяр гишүүн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Хоёрдугаарт, Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Гуравдугаарт, Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын зөвлөлийн дарга Б.Найдалаа танилцуулна.

Танилцуулгыг уншъя. ХҮН намаас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Бадрахын Найдлааг нэр дэвшүүлж байна.

Бадрахын Найдалаа 1975 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг.

1993 онд Нийслэлийн 23 дугаар дунд сургууль төгссөн.

1997 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч, санхүүч мэргэжлээр төгссөн.

2024 онд Япон Улсын Кобе их сургуулийн хөгжлийн эдийн засагч, эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

Ажилласан байдал нь:

1997-2000 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуульд Эдийн засгийн онолын багш,

2004-2008 онд Анод болон ХААН банканд Эрсдэлийн удирдлагын газрын захирал, эдийн засагч,

2008-2011 онд Эм Си Эс ХХК, Юнител ХХК-ийн газрын захирал,
2011-2020 онд Монголын эдийн засгийн форумын гүйцэтгэх захирал,
Монголын банкны холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга,

2016-2024 онд ХҮН намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн,
2024 оноос Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлийн даргаар ажиллаж байгаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшиж байгаа нэр дэвшигч Б.Найдалаагаас асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд Б.Найдалаа даргадаа баяр хүргэе. Тийм. Санал хураана шүү дээ.

Гишүүд үг хэлж дууслаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга нэр дэвшигчийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт явуулъя. /алх цохив/

94.7 хувиар дэмжигдлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан би өөрөө уншихъя. Нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Хоёр.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа танилцуулна.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын дэд хороодын бүрэлдэхүүнийг Та бүхэнд танилцуулъя.

Манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнд Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо, Соёл, спорт, залуучуудын дэд хороо байна.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүнд:

- 1.Цэндийн Баатархүү,
- 2.Дуламын Д.Бум-Очир,
- 3.Амгаланбаатарын Ганбаатар,
- 4.Жанчивын Галбадрах,
- 5.Сархадын Зулпхар,
- 6.Цэндсүрэнгийн Мөнхтуяа,
- 7.Дүгэрийн Рэгдэл,
- 8.Ганбатын Хосбаяр,
- 9.Бадарчийн Хэрлэн гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Дэд хорооны бүрэлдэхүүний талаар асуулт асуух гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байна уу?

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүнийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ингээд гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. /алх цохив/

63.2 хувиар дэмжигдлээ. Санал хураалт дууслаа.

Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа танилцуулна.

А.Ариунзаяа: Та бүхэндээ Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүнийг танилцуулъя.

- 1.Шинэбаярын Бямбасүрэн,
- 2.Даваасамбуугийн Ганмаа,
- 3.Мөнгөнцогийн Ганхүлэг,
- 4.Мөнхтөрийн Нарантуяа-Нара,
- 5.Мягмардашийн Сарнай,
- 6.Отгоны Саранчулуун,
- 7.Сүхбаатарын Эрдэнэбат,
- 8.Мөнхчулууны Энхцэцэг,
- 9.Доржзодовын Энхтуяа.

Л.Энхнасан: Баярлалаа.

Дэд хорооны бүрэлдэхүүний талаар асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу?

Д.Бум-Очир гишүүн тасаллаа. Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Энэ хоёр дэд хороонд давхцаж орохгүй юм уу? Аль нэгэнд нь л юм байна. Тийм үү?

Л.Энхнасан: Давхцаж орохгүй.

Д.Бум-Очир: Дэд хороонд уу?

Л.Энхнасан: Тийм.

Д.Бум-Очир: Би бол жишээ нь соёл руугаа бас ормоор л байна. Боловсролдоо ч бас баймаар л байгаа юм байна. Ойлголоо.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүнийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалтаа явуулъя. /алх цохив/

85 хувиар дэмжигдлээ. Санал хураалт явж дууслаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг гишүүн танилцуулъя.

Өнөөдрийн хурал дууслаа. Баярлалаа.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 11 цаг 26 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД